

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн ногдол ашиг нь ХНХ-аас хурлаас баталсан “Ногдол ашиг тараах журам”-д заасан нөхцлийн дагуу хуваарилагдана.

Ногдол ашиг хуваарилах бодлого

- Компани нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг өсгөн зохистой түвшинд байлгах зорилготой ажиллана.
- Компанийн ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн батлана.
- Компани тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө танилцуулана.
- Компанийн үйл ажиллагааны ашгаас хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хуваарилахдаа ногдол ашгийг бэлэн мөнгө, үнэт цаас, биет эд хөрөнгөөр олгож болно.
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-н шийдвэрийг нийтэд мэдээлэх бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байна.

Ногдол ашгийн хэмжээг тодорхойлох

- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан үзүүлэлт байна.
- Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна. Энэхүү дүн нь компанийн тухайн жилийн цэвэр ашгийн 20%-иас доошгүй хэмжээтэй байна.
- Компанийн тухай хуулийн дагуу ногдол ашиг хуваарилахад дараах нөхцлүүдийг хангасан байна
 - i. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх,
 - ii. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн дүн давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байна.

Ашиг хуваарилах

- Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд адил байна.
- Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- Компани хувьцаа эзэмшигчиддээ бэлэн мөнгөөр ногдол ашиг хуваарилахдаа хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансаар дамжуулан нэгдсэн журмаар олгоно.
- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой зааж, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусдаг байна.
- Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь бүртгэлийн өдрөөрх хувьцаа эзэмшигч этгээдэд үлдэнэ.
- Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаандаа ногдол ашгаа төлөх үүрэгтэй.
- Ногдол ашгаа хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлэлээр компани нь алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.